



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаадын иргэн, харьяатын Баруун бүс дэх газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/18/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2023 он	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Д.Балжинням Утас: 99495309 цахим хаяг: D.Baljinnyam@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	Error! Bookmark not defined.
5.1 Залруулсан алдаа	Error! Bookmark not defined.
5.2 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
5.3 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
5.4 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН
ДАРГА А.ХУАНБАЙ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын Баруун бүс дэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаадын иргэн, харьяатын Баруун бүс дэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт онцлох ажил гүйлгээ байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчид хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>67610522.70</u>	<u>130302149.60</u>
34	УРЬДЧИЛГАА	0.00	14000000.00
3471	Урьдчилгаа тооцоо	0.00	14000000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0.00	14000000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	67610522.70	116302149.60
354	Хангамжийн материал	66916145.70	116302149.60
35410	Бичиг хэргийн материал	5252260.00	5193890.00
35420	Аж ахуйн материал	10924081.58	24498481.58
35440	Түлш, шатах тослох материал	2057584.12	1889.12
35450	Барилгын засварын материал	405000.00	405000.00
35470	Бусад хангамжийн материал	48277220.00	86202888.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>225603194.55</u>	<u>264411781.22</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	225603194.55	264411781.22
392	Биет хөрөнгө	213108194.55	252411781.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	106129723.99	106129723.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-19740714.86	-23643957.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	229144082.75	325394082.75
39204	Хуримтлагдсан элэгдэл	-162187138.08	-179695471.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	139844469.96	107280569.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	-87552662.38	-87887288.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27876914.54	22161498.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20406481.37	-17327376.28
393	Биет бус хөрөнгө	12495000.00	12000000.00
39301	Програм хангамж	1980000.00	1980000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1485000.00	-1980000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12000000.00	12000000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>293213717.25</u>	<u>394713930.82</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>293213717.25</u>	<u>394713930.82</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	293213717.25	394713930.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12000000.00	12000000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	12000000.00	12000000.00
512	Хуримтлагдсан үр дүн	278375236.05	379875449.62
51210	Өмнөх үеийн үр дүн	301886539.46	278375236.05
51220	Тайлант үеийн үр дүн	-23511303.41	101500213.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2838481.20	2838481.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>293213717.25</u>	<u>394713930.82</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	696344301.78	659676006.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	99071701.78	139678606.90
120	Нийтлэг татварын бус орлого	99071701.78	139678606.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	99071701.78	139678606.90
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	99071701.78	139678606.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	597272600.00	519997400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	597272600.00	505997400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	597272600.00	505997400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	14000000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		14000000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	667670946.15	558175793.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	667670946.15	558175793.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	625445629.26	547057414.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	444179623.20	387718692.91
210101	Үндсэн цалин	275632646.38	225861114.80
210102	Нэмэгдэл	103571858.11	68176046.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58320006.71	67619465.31
210104	Урамшуулал	6655112.00	26062066.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58052864.39	48999528.63
210201	Тэтгэврийн даатгал	40020416.33	33508375.49
210202	Тэтгэмжийн даатгал	4508087.00	3942161.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	3606469.43	3106689.21
210204	Ажилгүйдлийн даатгал	901617.55	774394.83
210205	Эрүүл мэндийн даатгал	9016274.08	7667907.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15912785.28	15546600.00
210301	Гэрэл, цахилгаан	5776622.31	5665600.00
210302	Түлш, халаалт	3606662.97	494600.00
210303	Цэвэр, бохир ус	379500.00	129800.00
210304	Байрны түрээс	6150000.00	9256600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22733313.62	23063422.00
210401	Бичиг хэрэг	2774390.00	2578050.00
210402	Тээвэр, шатахуун	15463804.38	15177283.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1271419.24	891700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3131700.00	4416389.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6539738.00	4380088.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3515038.00	1861688.00
210604	Урсгал засвар	3024700.00	2518400.00
2107	Томилолт, зочны зардал	1996000.00	2109700.00
210702	Дотоод албан томилолт	1996000.00	2109700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8437531.00	6256070.00
210803	Даатгалын үйлчилгээ	356700.00	643200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	552031.00	345000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	111300.00	154000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1049000.00	750800.00
210807	Газрын төлбөр	28000.00	62400.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6295500.00	4300670.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61370678.77	58983313.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5695100.00	919900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1608600.00	622000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54066978.77	57441413.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42225316.89	11118378.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	3070597.00	1875950.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3070597.00	1875950.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39154719.89	9242428.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39154719.89	9242428.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>28673355.63</u>	<u>101500213.57</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-23511303.41</u>	<u>101500213.57</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	597272600.00	519997400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	597272600.00	519997400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	597272600.00	505997400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	597272600.00	505997400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	14000000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	14000000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	597272600.00	519997400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	597272600.00	519997400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	555047283.11	508879021.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	444179623.20	387718692.91
210101	Үндсэн цалин	275632646.38	225861114.80
210102	Нэмэгдэл	103571858.11	68176046.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58320006.71	67619465.31
210104	Урамшуулал	6655112.00	26062066.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58052864.39	48999528.63
210201	Тэтгэврийн даатгал	40020416.33	33508375.49
210202	Тэтгэмжийн даатгал	4508087.00	3942161.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	3606469.43	3106689.21
210204	Ажилгүйдлийн даатгал	901617.55	774394.83
210205	Эрүүл мэндийн даатгал	9016274.08	7667907.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15912785.28	15546600.00
210301	Гэрэл, цахилгаан	5776622.31	5665600.00
210302	Түлш, халаалт	3606662.97	494600.00
210303	Цэвэр, бохир ус	379500.00	129800.00
210304	Байрны түрээс	6150000.00	9256600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17271019.24	18840000.00
210401	Бичиг хэрэг	2930000.00	2275900.00
210402	Тээвэр, шатахуун	9400000.00	12899600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1276019.24	891700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3573000.00	2772800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6771560.00	17941100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	14000000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3746860.00	1422700.00

210604	Урсгал засвар	3024700.00	2518400.00
2107	Томилолт, зочны зардал	1996000.00	2109700.00
210702	Дотоод албан томилолт	1996000.00	2109700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2822031.00	2140400.00
210803	Даатгалын үйлчилгээ	356700.00	643200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	552031.00	345000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	111300.00	154000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1699000.00	890800.00
210807	Газрын төлбөр	28000.00	62400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	30000.00	45000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8041400.00	15583000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6432800.00	14961000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1608600.00	622000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42225316.89	11118378.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	3070597.00	1875950.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3070597.00	1875950.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	39154719.89	9242428.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39154719.89	9242428.46

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,000,000.00	2,838,481.20	304,076,005.25	318,914,486.45
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,000,000.00	2,838,481.20	304,076,005.25	318,914,486.45
C07	Тайлант үеийн үр дүн			-23,511,303.41	-23,511,303.41
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,000,000.00	2,838,481.20	280,564,701.84	295,403,183.04
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,000,000.00	2,838,481.20	257,053,398.43	295,403,183.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,000,000.00	2,838,481.20	280,564,701.84	295,403,183.04
D08	Тайлант үеийн үр дүн			101,500,213.57	101,500,213.57
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,000,000.00	2,838,481.20	382,064,915.41	396,903,396.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	505997400.00	496754972.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	505997400.00	496754972.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	504067400.00	496754972.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	395270500.00	387718692.91
210101	Үндсэн цалин	226847000.00	225861114.80
210102	Нэмэгдэл	70666700.00	68176046.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	70456000.00	67619465.31
210104	Урамшуулал	27300800.00	26062066.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50633800.00	48999528.63
210201	Тэтгэврийн даатгал	34745200.00	33508375.49
210202	Тэтгэмжийн даатгал	4015300.00	3942161.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	3175800.00	3106689.21
210204	Ажилгүйдлийн даатгал	794200.00	774394.83
210205	Эрүүл мэндийн даатгал	7903300.00	7667907.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15546600.00	15546600.00
210301	Гэрэл, цахилгаан	5665600.00	5665600.00
210302	Түлш, халаалт	494600.00	494600.00
210303	Цэвэр, бохир ус	129800.00	129800.00
210304	Байрны түрээс	9256600.00	9256600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18840000.00	18840000.00
210401	Бичиг хэрэг	2275900.00	2275900.00
210402	Тээвэр, шатахуун	12899600.00	12899600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	891700.00	891700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2772800.00	2772800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3941100.00	3941100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1422700.00	1422700.00
210604	Урсгал засвар	2518400.00	2518400.00
2107	Томилолт, зочны зардал	2111600.00	2109700.00
210702	Дотоод албан томилолт	2111600.00	2109700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2140400.00	2140400.00
210803	Даатгалын үйлчилгээ	643200.00	643200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	345000.00	345000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154000.00	154000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	890800.00	890800.00
210807	Газрын төлбөр	62400.00	62400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45000.00	45000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15583400.00	15583000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14961000.00	14961000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	622400.00	622000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1930000.00	1875950.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1930000.00	1875950.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1930000.00	1875950.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	505997400.00	496754972.00

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	506891600.00	505997400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	506891600.00	505997400.00

2.6 Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	14000000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	14000000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	14000000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	14000000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	14000000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	14000000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	14000000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	14000000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Гадаадын иргэн, харьяатын Баруун бүс дэх газар нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишигт хүрсэн нээлттэй, хариуцлагатай үйл ажиллагааг явуулах гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсад зорчих түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл олгох, хугацааг сунгах хувийн урилга олгох, гадаадын иргэнийг цахим үнэмлэх олгох,
- Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх,
- Иргэний харьяалал, цагаачлал, гадаадын гэр бүлд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх, олон улсын болон гадаадын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газартай холбоотой асуудлыг шийдвэрлэх,
- Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх,

Байгууллагын даргын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/150 дугаар тушаалаар тус газар нь Увс аймаг дахь хэлтэстэй болж, нийт батлагдсан орон тоо 27, одоогоор 26 албан хаагч ажиллаж байна.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Ховд аймгийн Засаг даргын тамгын газрын иргэний танхимд зохион байгууллаа. Тус өдөрлөгт Монгол Улсад оршин сууж буй 6 орны 30 гадаадын иргэн, 3 төрийн бус байгууллагын төлөөлөгч, хууль хяналтын байгууллагын албан хаагчид, үйлчилгээ үзүүлдэг аж, ахуй нэгжийн төлөөлөл оролцсон бөгөөд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, шинэчлэн батлагдсан журмууд, бусад холбогдох хууль тогтоомжуудыг сурталчилж, цахим виз, цахим үйлчилгээний системийн талаар иргэдэд дэлгэрэнгүй мэдээлэл, зөвлөгөө өгч, үйлчилгээг үзүүлсэн байна.

Мөн дээд газраас ирүүлсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Үүнд: Захиргаа, удирдлагын газраас ирүүлсэн 40, Хяналт шинжилгээ, дотоод аудитын газарт 4, Виз, зөвшөөрлийн газраас ирүүлсэн 3, Санхүүгийн хэлтсээс ирүүлсэн 1, Залуучуудын зөвлөлөөс ирүүлсэн 1, Гадаад харилцаа, хамтын

ажиллагааны хэлтсээ ирүүлсэн 5, Мэдээлэл технологийн хэлтсээс ирүүлсэн 2, нийт 56 дотоод албан бичгийг хүлээн авч, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Гадаадын иргэн, харьяатын Баруун бүс дэх газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад санхүүгийн тайлан гаргахын өмнө тооцоо тооллого хийж, хяналт тавин ажилласан байна.

ХЗДХ яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гадаадын иргэн, харьяатын Баруун бүс дэх газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гадаадын иргэн, харьяатын Баруун бүс дэх газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 101.5 сая төгрөгөөр буюу 13.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	14000.0	14000.0
Бараа материал	67610.5	116302.1	48692.0
Үндсэн хөрөнгө	225603.1	264411.7	38808.5
Нийт хөрөнгө	293213.7	394713.9	101500.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	293213.7	394713.9	101500.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	293213.7	394713.9	101500.2

Дээрх хүснэгтээс харахад Гадаадын иргэн, харьяатын Баруун бүс дэх газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 101500.2 мянган төгрөгөөр өссөнд материаллаг нөлөө үзүүлж байгаа данс нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг бараа материалын үнийн өсөлт, урсгал засвар хийгдэх шаардлагын улмаас өмнөх оны гүйцэтгэл дээр 53.0 сая төгрөгөөр санхүүжүүлэх эх үүсвэрийг нэмэгдүүлж улсын төсвөөс 558.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 53.0 сая төгрөгөөр бууруулж 505.9 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлангийн хугацаанд тухайн байгууллага нь улсын төсвөөс 505.9 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 496.7 сая төгрөгийн зардал санхүүжүүлж, 9.2 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар суудлын авто машины дэмжлэг 20.0 сая төгрөгийн санхүүжилтийн 70% болох 14.0 сая төгрөгийн

санхүүжилт орж, гүйцэтгэлээр нээлттэй тендерт шалгарсан Мөнх Цаст хаан ХХК-д шилжүүлж, санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын Баруун бүс дэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Д.Балжинням 2022 оны 01 дүгээр сарын 27-ноос 01 дүгээр сарын 30-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар, аудитын менежер А.Цэцэгсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 14/06 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 725.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 14.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 11.6 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2 - 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Гадаадын иргэн, харьяатын Баруун бүс дэх газрын үйл ажиллагаанд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 9 дүгээр зүйлд заасан албан томилолт, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэл, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлийн 15.2 -ын зарим заалтууд хамаарахгүй байна.

8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцастай холбоотой тус газраас зардал санхүүжүүлээгүй бөгөөд дээд шатны байгууллагаа 67 төрлийн 73.8 сая төгрөгийн үнэ бүхий дүрэмт хувцас ирж үнэ төлбөргүйгээр бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Тус хуулийн 15.2 зааснаар төсөвт байгууллага хот дотор албан тушаалын суудлын авто машин ашиглаагүйтэй холбоотой тээвэр шатахууны зардал, цалин хөлсийг гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгосноор батлагдсан төсвийг 9.2 сая төгрөгөөр хэмнэж дээд шатны байгууллагын дансанд татан төвлөрүүлсэн байна.

Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5 -д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тухайн байгууллагад тайлант онд зарцуулсан шатахууны жолоочийн замын тооцооны хуудасны тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргаагүй, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой 2.0 сая төгрөгийн төлбөрийн акт, хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см³-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг авто машинаар 3610 км зам туулахад 722 литр буюу 1.8 сая төгрөгийн зардал гаргаж Засгийн газрын тогтоолыг хэрэгжилтийг ханган ажиллаагүй зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг тайлант онд бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

/мянган төгрөгөөр/

Акт	1	2000.0	1	2000.0	100
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	1800.0	3	1800.0	100
Нийт дүн	4	3800.0	4	3800.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудалд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 20.0 сая төгрөгийн үнийн дүнтэй Мөнх Цаст ХААН ХХК-ны нийлүүлэх Toyota prius 20 авто машиныг техникийн тодорхойлолт, стандартад заасан үзүүлэлтэд нийцсэн авто машин нийлүүлж гэрээний хэрэгжилтийг хангасан эсэхийг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.9 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс 1.9 сая төгрөгийн алдаа зөрчилд дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө

5.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй

5.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлээгүй болно.

5.4 Зөвлөмж

5.4.1 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд цалингийн сангаас тооцсон ХАОАТ дүн, харилцахаас харилцагч байгууллага руу шилжүүлсэн дүн зөрүүтэй, харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчил дутагдал илэрлээ

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 2.6.-д “хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах, гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Харилцагч байгууллагатай зардлын санхүүжилтийн тооцоог тулган баталгаажуулж өглөгийн тооцоо үүсвэл дараа оны санхүүгийн тайлангийн 1 дүгээр улирлын тайланд залруулга хийх. Залруулга хийгдсэн тохиолдолд Төрийн аудитын газарт залруулга хийгдсэн тухай албан тоот ирүүлэх.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Залруулга хийгдээгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд цалингийн сангаас тооцсон ХАОАТ дүн, харилцахаас харилцагч байгууллага руу шилжүүлсэн дүн зөрүүтэй, харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчил дутагдал илэрлээ	1	1,971.9	-	-	-	-	1	1,971.9
Дүн	1	1,971.9	-	-	-	-	1	1,971.90

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Д.БАЛЖИННЯМ

